Төсөл хэрэгжүүлэгч:
“Болоржонш” ХХК

ДУНДГОВЬ АЙМАГ, БАЯНЖАРГАЛАН СУМЫН НУТАГТ ХЭРЭГЖИЖ БУЙ ЖОНШ БАЯЖУУЛАХ ҮЙЛДВЭРИЙН ТӨСЛИЙН 2026 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ТАЙЛАН

Улаанбаатар хот

2026 он

Батлав: БОУАӨЯ-ны ХБОБХГ-ын дарга

.....Г.Энхмөнх

Зөвшөөрч, хэрэгжүүлэх үүрэг хүлээсэн:
“Болоржонш”ХХК-ний захирал ……..…… ЖАО ХУЙ

ДУНДГОВЬ АЙМАГ БАЯНЖАРГАЛАН СУМЫН НУТАГТ ОРШИХ ЖОНШ БАЯЖУУЛАХ ҮЙЛДВЭРИЙН ТӨСЛИЙН 2026 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

(Аж ахуйн нэгжийн регистрийн дугаар: 2830701)

Хянасан: БОУАӨЯ-ны ХБОБХГ-ын мэргэжилтэн

.....

Боловсруулсан:
“Болоржонш” ХХК-ийн, байгаль орчны мэргэжилтэн

..... Ж.Оюунжаргал

ДУНДГОВЬ АЙМАГ
БОЛОРЖОНШ ХХК
ЗАН0009 2830701

Улаанбаатар
2026 он

ГАРЧИГ

БҮЛЭГ 1. ТӨСЛИЙН ТОДОРХОЙЛОЛТ 2
1.1 Төслийн ерөнхий мэдээлэл: 2
1.2 Төслийн хүчин чадал: 3
1.3 Үйлдвэрийн технологи 3
1.4 Үйлдвэрт хэрэглэгдэх химийн бодис 4
1.5 Үйлдвэрийн тоног төхөөрөмж 4
1.6 Дэд бүтэц 4
БҮЛЭГ 2. ТӨСЛИЙН ТАЛБАЙ, ТҮҮНИЙ ОРЧНЫ БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ 5
БҮЛЭГ 3. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ 6
БҮЛЭГ 4. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ 8
4.1 Байгаль орчны менежментийн тухайн жилийн төлөвлөгөөний гол зорилт 8
4.2 Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ 9
4.3 Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө 11
4.4 Тохижилт ногоон байгууламжийн төлөвлөгөө 13
4.5 Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө 13
4.6 Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр 15
4.7 Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага, зохион байгуулалтын төлөвлөгөө 18
4.8 БОМТ, түүний хэрэгжилтийг оролцогч, сонирхогч талуудад тайлагнах, хэлэлцүүлэх хуваарь 18

БҮЛЭГ 1. ТӨСЛИЙН ТОДОРХОЙЛОЛТ

1.1 Төслийн ерөнхий мэдээлэл:

Төсөл хэрэгжүүлэгч: “Болоржонш”ХХК

Улсын бүртгэлийн дугаар: 9019087082
Регистрийн дугаар: 2830701


Төслийн нэр: Жонш баяжуулах үйлдвэр

Төсөл хэрэгжүүлэгчийн хаяг: Дундговь аймгийн Баянжаргалан сум, 3-р баг Аргатай, Баянхошуу сумын төв. Утас: 88331199

Газар ашиглах зориулалт: Уул уурхайн үйлвэрлэлийн барилга байгууламж

Төслийн зорилго: "Болор жонш " ХХК нь өөрийн эзэмшлийн Зүүн аргатай орд болон Баянжаргалан сум орчимд хувиараа жонш олборлогч хувь хүн, аж ахуй нэгжүүдийн жоншийг худалдан авч, баяжуулах үйлдвэртээ боловсруулан 95% агуулгатай нэмүү өртөг шингэсэн эцсийн бүтээгдэхүүн болох жоншны баяжмал гарган экспортолж улс, орон нутгийн хөгжилд хувь нэмэр оруулах зорилготой.

Төслийн байршил: Дундговь аймгийн Баянжаргалан сумын Аргатай /3-р/ багийн нутагт байрлана.



Зураг 1. Сансрын зураг

1.2 Төслийн хүчин чадал:


Баяжуулах үйлдвэр нь 100000 тн хайлуур жоншны хүдэр баяжуулахаар төлөвлөсөн. Баяжуулах үйлдвэр нь жилд 70 хоногийн сул зогсолттой байхаар мөн төлөвлөгөөт ба урсгал засварын хоногийг тооцож жилд 270 хоногт хэвийн үйл ажиллана.

Баяжуулах үйлдвэрийн нөөц: жилд 100,000.0 т/жил
Хоногт 370-400 т
Цагт 15.4-16.6 т

Үйлдвэрийн ашиглалтын коэффициент: 94.7%.

1.3 Үйлдвэрийн технологи

Үйлдвэр нь хүдэр хүлээн авах, хүдэр жигдрүүлэлт, хүдэр бутлах, нунтаглан баяжуулах, баяжмал үсгүйжүүлэх, савлах хэсгүүдээс бүрдэнэ.



Зураг 1.Технологийн схем

1.4 Үйлдвэрт хэрэглэгдэх химийн бодис

Урвалжийн хэсэг нь баяжуулах үйлдвэрийн үндсэн хэсгийн нэг бөгөөд түүний үйл ажиллагаа нь хүдэр баяжуулалтын технологид чухал нөлөө үзүүлдэг. Энэ хэсгийн гол зорилго нь технологийн процесст хэрэглэгдэж байгаа урвалжуудыг зохих технологийн дагуу уусгаж өгөгдсөн концентрацитай уусмал бэлтгэх, баяжуулах процессыг тасралтгүй хангах, урвалжууд болон уусмалуудыг хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зааврын дагуу хүлээн авах, уусгах, зөв хадгалах юм.

Хүснэгт 1. Урвалж бодисын концентраци

Цуглуулагч урвалж	Тосны хүчил (C17H33COOH)	1.5 %
Орчин тохируулагч урвалж	Техникийн сод (Na2CO3)	5.0 %
Дарагч урвалж	Шингэн шил (Na2SiO2)	3.5 %
Тунадасжуулагч урвалж	Полиакриламид (C3H5NO)n	0.05%
Кальцит дарагч урвалж	Цардуул (C6H10O5)	1.5%

Өдөр тутмын урвалжийн торх болон хэмжин хуваарилах насосны станц байх ба хяналтын өрөөнөөс шууд удирдаж ажиллана. Урвалж бодисыг технологийн процесст уусмал байдлаар өгөх бөгөөд дараах концентрацитай байна.

1.5 Үйлдвэрийн тоног төхөөрөмж

Үйлдвэр нь технологийн хувьд 2 шатны бутлуур, 1 шигшилт, нунтаглалт, мушгиа ангилалт, 1 шатны үндсэн флотаци, 7 шатны цэвэрлэгээний флотаци, 2 шатны хяналтын флотаци, баяжмалыг өтгөрүүлэн шүүж хатаах, хаягдлыг санд байршуулан тунгааж эргэлтийн усыг дахин ашигладаг.

1.6 Дэд бүтэц

Зам тээвэр

Баяжуулах үйлдвэр нь Дундговь аймгийн Баянжаргалан сумын Аргатай багийн нутагт орших бөгөөд Баянжаргалан сумын төвөөс 2.8 км, Улаанбаатар хотоос зүүн урагш 250 км, Улаанбаатар төмөр замын “Чойр” өртөөнөөс баруун урагш 83 км шороон сайжруулсан замаар тээвэрлэж Чойр төмөр замын өртөөнөөс БНХАУ-ын Эрээн хот хүртэл төмөр замаар тээвэрлэнэ.

Ус хангамж

Төслийн хугацаанд хоногт 371.85 м3 ус ашиглах бөгөөд 15 л/сек (1296м3/хон) нийлбэр ундаргатай 4ш өрөмдмөл худгаас хангахад ус ашиглах боломжит нөөцийн хэмжээ хүрэлцээтэй байна**.**

БҮЛЭГ 2. ТӨСЛИЙН ТАЛБАЙ, ТҮҮНИЙ ОРЧНЫ БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

Гадаргуугийн хувьд далайн түвшнээс дээш 1100-1200 м өргөгдсөн жижиг толгод гүвээ хэлбэрийн мөлгөржсөн хэсэгт багтан, Хэнтий нурууны төгсгөл, говийн бүсийн эхлэлийн зааг бүхий хэсэгт оршдог. Хамгийн өндөр цэгүүд нь далайн түвшнээс дээш 1305-1320 м өргөгдсөн товгор уулс бөгөөд тэдгээр нь харьцангуй залуу гүний чулуулгаас тогтох учир барзгар гадаргуутай, эргэн тойрон 20-50 км зайд үзэгдэх байдал сайтай байдаг.Урагшлах тусам газрын гадаргуу намсч, мөлгөржин жижиг гүвээ, толгод болон хувирдаг ба харьцангуй өндөржилт нь 10-50 м-ээс хэтэрдэггүй.

Хөрс ургамал: Шимт хөрсний зузаан 5-20 см, цөөн тохиолдолд 40 см /нуур орчим/ хүрдэг, хүрэн, бор өнгөтэй, ургамлын бүрхэвч сийрэг, түүний төрөл цөөн, годуу таана, хүмүүл, агь, шарилж, зангуу ургадаг, харин нуур тойрмоо дагаж бага хэмжээгээр нугын янз бүрийн ургамал ургана. Модгүй, жалга, нугачаа дагаж цөөн тоогоор хайлаас, тоорой энд тэнд ургасан байдаг. Мөн бага тархацтайгаар буйлс, дэрс, харгана, тоорой ургасан нь элбэг тохиолдоно. Ан амьтан: Амьтны ертөнц нилээд олон төрөлтэй, араатан амьтдаас үнэг, чоно, мануул, хярс, дорго элбэг. Харин уулархаг хэсэгтээ цөөн тоогоор аргаль, янгир, тал хэсэгтээ нилээд олноор зээр, хар сүүлт тааралдана. Жигүүртний аймгийн төлөөлөгчид хамгийн элбэг: бүргэд, харцага, тоодог, тогоруу, ногтруу болон бусад жижиг шувуу олон байдаг.

Цаг уур: Тухайн район нь эх газрын эрс тэс уур амьсгалтай, улирлын ба хоногийн температурын хэлбэлзэл ихтэй, хур тунадас багатай хуурай агаартай, цаг агаарын олон жилийн ажиглалтын (1938-1998 он) дунджаар хамгийн хүйтэн 12-р, 1-р сард болдог ба -23 ~ -24ºС, хамгийн халуун үе 6-8-р сард +25 ~ +30ºС орчим болдог. Жилийн дундаж хур тунадас 113 мм ба үүний дийлэнх хэсэг нь 6- 9 -р сард /90 мм/ бороо хэлбэрээр буудаг байна. Салхи гол төлөв баруун хойноос зүүн урагш чиглэлтэй, салхины жилийн дундаж хурд 4.7 м/сек гэх боловч хавартаа 15-20 м/сек хүрэх тохиолдол элбэг байдаг.

Ус зүй: Тухайн районы нэг онцлог нь тогтмол урсацтай гол горхи байдаггүй, зөвхөн Аргатай, Элгэн, Гашуун хар, Хужирт зэрэг жижиг булгуудттай, харин уужим хөндийнүүддээ хужиртай жижиг шанд тойрмууд нилээд элбэг байлаг. Хөндий амууддаа худаг элбэг, тэдгээрийн ударга нь 200-1600 л/цагт хэлбэлздэг боловч ихэнх усны чанар нь ундны усанд тохиромж муутай байдаг. Жонш баяжуулах үйлдвэрийн дэргэд гаргасан Энгэр-Усны багийн гүний худгууд нь ахуйн болон үйлдвэрийн хэрэглээний усны хэрэгцээг хангаж байна.

Хүн ам зүй, дэд бүтэц: Зам харгуйн хувьд орон нутгийн энгийн шороон замуудтай бөгөөд хавь ойрын суурин газар, төвүүдийн хооронд шууд холбосон байдаг. Талбайн аль ч хэсгээр жилийн ямар ч улиралд явах боломжтой, харин томоохон хөндийнүүд нь зуны бороотой үед хужиртай тойром, намагтай болдог тул тэр болгон зам харгуйн хэсгээр туулах боломж муу байдаг. Хүн ам цөөнтэй, гол төлөв малчид нүүдэллэн амьдардаг, 1км² талбайд 0.2-0.6 хүн ноогддог, хүн ам арай илүү шигүү суурьшилттай нь Говь-Угтаал, Баянжаргалан сумын төв, Морьт, Хонгор, Энгэр-Усны багийн төвүүд юм. Тэнд сургууль, цэцэрлэг, холбоо, эмнэлэг, дизель станц, дэлгүүр, худалдааны газрууд ажилладаг.

БҮЛЭГ 3. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

Төслийн үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлэх гол ба болзошгүй сөрөг нөлөөллийг магадлан жагсаах арга болон Леопольдийн матриц үнэлгээний аргаар үнэлж тодорхойлсон.

Хүснэгт 2. Гол болон болзошгүй сөрөг нөлөөлөл

Гол сөрөг нөлөөллүүд		**Болзошгүй сөрөг нөлөөллүүд**	
Нөлөөлөл	**Нөлөөллийн зэрэг**	**Нөлөөлөл**	**Нөлөөллийн зэрэг**
Агаарын чанарт үзүүлэх нөлөөлөл			
1. Тоосжилт 2. Хийн бохирдол 3. Дуу шуугиан	Дунд Дунд Дунд	1. Үнэр 2. Үйл ажиллагаа зогссон үед усны эргэлтгүй үед үүсэх үнэр 3.Техникийн эвдрэлээс үүсэх дуу чимээ/ муудах /	Бага Их Дунд
Газрын хэвлий, газрын гадарга, газар ашиглалтад үзүүлэх нөлөөлөл			
4. Газрын хэвлий, гадаргын эвдрэл үүсэх 5. Газрын гадаргын төрх байдал өөрчлөлт орох 6. Малын бэлчээр малчдын нүүдлийн зам хуваагдах	Их Дунд Дунд	-	
Хөрсөн бүрхэвчид үзүүлэх нөлөөлөл			
7. Үржил шимт хөрс хуулагдах 8. Хөрсний элэгдэл, талхагдал 9. Голын нуга татмын хөрсөн бүрхэвч эвдэрч элэгдэн чанар буурах	Их Дунд Дунд	3. Хөрсөн бүрхэвч бохирдож үржил шимт чанараа алдах	Дунд
Гадаргын болон газрын доорх усанд үзүүлэх нөлөөлөл			
10.Усан хангамжийн нөлөөлөл	Бага	4. Гадаргын усанд тунадас, булингар үүсч, чанар нь доройтох 5. Шатахуун түлш, барилгын материалын асгаралтаас гадаргын ус бохирдох 6. Үер усны эрсдэл 7. Газрын доорх усны бохирдол / багасалт /	Бага Дунд Бага Дунд
Ургамлан бүрхэвчид үзүүлэх нөлөөлөл			
11.Ургамлан нөмрөг хуулагдах	Их	8.Тоосжилт, тал хагдал, дарагдлаас ургамлан бүрхэвч гэмтэж, амьдрах чадвар нь доройтох	Дунд
12.Ургамлан бүрхэвч талхлагдаж, ургах орчин доройтох	Дунд	9. Хөрсөн бүрхэвч бохирдсоноос ургамлын амьдрах чадвар	Дунд

		алдагдах	
Амьтны аймагт үзүүлэх нөлөөлөл			
13. Шавьж жижиг мэрэгч, мөлхөгч амьтдын үүр оромж хөндөгдөх 14. Амьтан үргэж дайжих, хорогдох	Дунд Дунд	10. Шувуудын үржлийн нутаг өртөх 11. Ховор амьтны амьдрах орчин өртөх	Дунд Бага

Жонш баяжуулах үйлдвэр нь тухайн газар нутгийн төлөв байдал, онцлогийг харгалзан үзэж, учирч болзошгүй сөрөг нөлөөллийг нарийвчлан үнэлж, газарт нэмж барилга байгууламж барихгүй ч гэсэн үйл ажиллагааны явцад байгаль орчинд учирж болзошгүй нөлөөллөөс сэргийлэх, бууруулах арга хэмжээг тусгайлан боловсруулан менежментийн төлөвлөгөөнд тусгаж өгөв.

БҮЛЭГ 4. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

4.1 Байгаль орчны менежментийн тухайн жилийн төлөвлөгөөний гол зорилт

Энэхүү төлөвлөгөөг боловсруулахдаа байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний тайланд тусгасан байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө болон орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг үндэслэн байгаль орчныг хамгаалах талаар авах удирдлага зохион байгуулалтын болон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээ, уг төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардагдах хугацаа, хөрөнгө зардлыг бодитойгоор тооцож тусгах зорилт тавилаа.

Байгаль орчинд үзүүлэх аливаа сөрөг нөлөөллийг бууруулан ажиллах, сөрөг нөлөөлөл багатай байхын тулд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлэх шаардлагатай.

- Байгаль орчны бохирдолоос сэргийлэх, байгалийн нөөц баялгийг зүй зохистой ашиглах зорилгоор байгаль орчинд учрах нөлөөллийг хамгийн бага байлгахад анхаарах
- Байгаль орчныг хамгаалах тухай хууль тогтоомж, бусад холбогдох хууль, дүрэм, журам, стандартуудыг мөрдлөг болгон ажиллах
- Үйлдвэрлэлийн барилга байгууламжийг ашиглах өргөтгөх үед нөлөөлөлд өртөх талбайг хамгийн бага байлгах
- Байгаль орчныг хамгаалах, ажилчдын аюулгүй байдлыг хангах үүднээс ажилчдад сургалт зохион байгуулах
- Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг батлуулж, төлөвлөгөөний дагуу мониторинг, хяналт-шинжилгээ хийлгэх
- Компанийн ажилтнууд, нутгийн иргэд болон сонирхогч талуудад байгаль орчны асуудлыг нээлттэй, шударга, ил тод байлгах

4.2 Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ

Гол ба болзошгүй сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх бууруулах арга хэмжээ	Арга хэмжээний цар хүрээ	Хэрэгжүүлэх хугацаа давтамж	Нэгжийн зардал (сая.төг)	Нийт зардал сая.төг	Баримтлах стандарт, аргачлал
Агаар орчинд үзүүлэх нөлөөллийг бууруулах чиглэлээр						
Тоосжилт үүсэх	Мананцар үүсгэгч төхөөрөмж	Баяжуулах үйлдвэрийн бутлуураас үүсэх тоосжилт	Эхний улиралд	5.5	5.5	Агаарын бохирдлын төлбөрийн тухай хууль; Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага MNS 4585:2025 Бензин хөдөлгүүртэй авто машин-Утааны найрлага дахь хорт бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ ба хэмжих арга MNS 5013:2009 Дизель хөдөлгүүртэй авто машин-Утааны тортогжилтын зөвшөөрөгдөх дээд хэмжээ ба хэмжих арга MNS 5014:2009
	Тоосжилт бууруулах төлөвлөгөөт усалгааг 4-9 саруудад хур борооны давтамжаас хамааруулан 7 хоногт 2-3 удаа усалж байх	Машин механизмын хөдөлгөөнөөс үүсэх тоос тоосонцор	7 хоногт 2-3 удаа	-	-	
Утаа болон хийн бохирдол үүсэх	Агаарын бохирдлын тухай хуулийн дагуу техник хэрэгслийн татварыг төлөх, оншилгоонд хамрагдах	Хүнд даацын машин механизм болон суудлын машин техник	Жилд 1удаа (I-II улиралд)	-	-	
Газрын гадарга, Хөрсөн бүрхэвчид үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр						
Хөрсний элэгдэл, эвдрэл, бохирдол бий болох	Засварын газар болон ахуйн хог хаягдлын талбайг хатуу хучилттай болгох	Хог хаягдлын 3 $м^2$ газар болон 5-10 $м^2$ засварын газар	II Улиралд	-	-	Байгаль орчныг хамгаалах тухай хууль: Зүйл 25-2; Газрын хэвлийн тухай хууль: Зүйл 41-1, 2, 3, 4; Газрын тухай хууль 56дугаар зүйл 56.6
	Тээврийн замын маршрут дагуу хайрган хучилтыг нэмэгдүүлэх	Тээвэрлэлтийн 1.5 км замын засвар арчилгааг тогтмол хийх	төлөвлөгөөт онд	-	-	
	Олон салаа шороон зам үүсэхээс хамгаалж замын маршрут чиглэл заасан тэмдэг тэмдэглэгээ тавих	Баянжаргалан сумаас үйлдвэр хүртлэх 1.5 км зам болон дотоод зам	II Улиралд	-	0.1	
	Хаягдлын сан нь байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлэхгүй байхаар хийгдсэн байх	Хаягдлын сан доторлогоо болон далан битүүмлэл	II Улиралд	-	-	
Ахуйн бохир хадгалах цооног, шугам хоолойд гэмтэл	Ахуйн бохир хадгалах цооног, шугам хоолойд байнгын үзлэг, шалгалт хийж байх шаардлагатай.	Ахуйн бохир хадгалах цооног, бохир дамжуул ах шугам, хоолойг засах	төлөвлөгөөт онд	-	-	

гарсны улмаас хөрс бохирдож болзошгүй	Эвдрэл гэмтэл гарсан тохиолдолд нэн даруй засаж сэлбэх үйл ажиллагааг хэрэгжүүлэх хэрэгтэй					
Гадаргын болон газрын доорхи усанд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр						
Технологийн хэрэгцээнд, унд ахуйн хэрэгцээнд, тоосжилт зам усалгаанд, ногоон байгууламж, уурын зууханд газрын доорх ус ашигласнаар нөөц горимд нөлөөлөх, Хаягдлын сангаас ус шүүрэх	Ус ашиглах гэрээ байгуулан, төлбөрөө төлнө	Ус ашиглах боломжит нөөцийн тооцоонд тусгагдсаны дагуу ашиглах	I улиралд гэрээ байгуулах	-	-	Усны тухай хууль, Ус бохирдуулсны төлбөрийн тухай хууль “Усан орчны чанарын үзүүлэлт” MNS 4586:1998. ”Газар доорх усыг бохирдлоос хамгаалах” MNS 3342:1982.
	Унд ахуйн болон бусад хэрэгцээнд усыг ариг гамтай, алдагдал багатайгаар ашиглах, ус хэмнэлтэтийн төхөөрөмж суурьлуулах	Ус хэмнэх төхөөрөмж/ариун цэврийн өрөө болон гал тогоо 6ш/	I улиралд	0.9	0.9	
	Ашиглаж байгаа худгийг тоолууржуулах болон цаг тухайд нь баталгаажуулах	Баяжуулах үйлдвэрийн нийт 4ш гүний худагт	Төслийн хугацаанд	1.0	1.0	
	Ашиглаж бүй гүний худагт хамгаалалтын байр барих	Баяжуулах үйлдвэрийн нийт 4ш гүний худагт	төлөвлөгөөт онд	-	-	
	Хаягдлыг хуурай аргаар зайлуулах тоног төхөөрөмж	Баяжуулах үйлдвэр	2026-2027	-	-	
Ургамал нөмрөгийг хамгаалах чиглэлээр						
Ургамлан нөмрөг устах, хөл газрын ургамал ихсэх	Хамгаалалтын ногоон зурвас байгуулна төслийн талбайн зүүн хойд талд	500ш шар хуайс тарих /Эзэмшлийн талбайн 10 хувь/	Ногоон байгууламжийн зардалд тусгагдсан			Ургамал хамгааллын тухай” хууль: Зүйл 8-1, 2 Байгалийн ургамлын тухай” хууль: Зүйл 7. Ургамлыг хамгаалах; MNS 5918:2008 “Эвдэрсэн газрыг ургамалжуулах. Техникийн ерөнхий шаардлага”
Амьтны аймгийг хамгаалах чиглэлээр						
Амьдрах орчин алдагдах, тоо толгой багасах	Орон нутгийн амьтан хамгаалах үйл ажиллагаанд оролцох	-	-	Нийгмийн хариуцлагын хүрээнд		Амьтны аймгийн тухай хууль: 6.1.7 дахь заалт: үйлдвэрлэл, аж ахуйн үйл ажиллагааны явцад амьтан хөнөөгдөхөөс сэргийлэх
	Хууль бусаар ан амьтан агнах, гаршуулах, гэрэл чийдэн тусгаж сэлгүүцэж амьтадыг айлгах, хөөн зайлуулах үйлдлийг хатуу хориглоно. Ажилчдад мэдлэг олгох сургалт хийх, санамж тэмдэг байршуулах	-	-	-	-	

НИЙТ 5 610 мян.төг

4.3 Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө

Гол ба болзошгүй сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх бууруулах арга хэмжээ	Арга хэмжээний цар хүрээ	Хэрэгжүүлэх хугацаа давтамж	Нэгжийн зардал мян.төг	Нийт зардал сая.төг	Баримтлах стандарт, аргачлал
Ахуйн хог хаягдал						
Ахуйн болон үйлдвэрлэлийн хог хаягдлын нөлөөгөөр хөрс, ус, агаар бохирдох, ажилчдын эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөх	Хог хаягдлыг ангилан ялгаж, дахин ашигладаг тогтолцоог нэвтрүүлэх	Ангилан ялгах пүнкер авах	I улиралд	-	-	БОАЖСайдын А/349 дугаар тушаалын Засгийн газрын 2018 оны 116 дугаар тогтоол
	Ахуйн хог хаягдлын гэрээг Баянжаргалан сумын ЗДТГазартай байгуулж төслийн талбайд үүссэн бүх хатуу хог хаягдлыг цуглуулж нэгдсэн цэгт хүргэж устгах	Гэрээт компаниар тээвэрлүүлэн хог хаягдлын нэгдсэн цэгт хаях	Сар бүр	-	-	
	Хог хаягдлыг цуглуулах савыг битүүмж сайтай хийх, ажилчдын байр, оффис, агуулах, ШТС зэрэг газарт байрлуулах, засварлаж байх	Төмөр, шил, хуванцар сав зэргийг 2 догч түүхий эд авах цэгт нийлүүлэх	Сар бүр	100.0	1.0	Хог хаягдлын тухай хууль Хог хаягдлын тухай хуулийн 15-р зүйл
	Хог хаягдал түр хадгалах цэгийн талбайг нэвчилт явагдахаргүй, ирмэг хөвөө бүхий цементэн суурьтай болгон тохижуулах	цементэн суурь	II улиралд	-	0.5	
Ахуйн шингэн хог хаягдал						
Бие засах газар ахуйн бохир усны нөлөөгөөр байгаль орчин бохирдох	Бие засах газар, бохир усны цооногийг тогтмол ариутгаж, халдваргүйжүүлж байх	Бохир усны цооног	Сар бүр	-	-	Хог хаягдлын тухай хууль
Аюултайн хог хаягдал						

Тээврийн хэрэгслээс гарах аюултай хог хаягдал	Ашиглагдсан тос, тосолгооны материал, аккумляторыг тусгай цэг гарган хуримтлуулах, түр хуримтлуулах цэгийг тохижуулах	Аюултай хог хаягдал хадгалах цэг	I Улиралд	500.0	0.5	Хог хаягдлыг тухай хууль /шинэчилсэн найруулга/ 2017-05-12 Засгийн газрын 2018 оны 116 дугаар тогтоол
Тээврийн хэрэгслээс гарах аюултай хог хаягдал болон химийн бодисын үлдэгдэл сав баглаа боодол	Ашигласан тос тосолгооны материалыг дахин боловсруулах үйлдвэрт нийлүүлэх, гэрээ байгуулах	Хуримтлагдсан тос масло	Жилд 1 удаа	-	-	
	Химийн бодисын үлдэгдэл болон сав баглаа боодлыг мэргэжлийн байгуулгатай гэрээ хийж устгуулах	ХБ –н сав баглаа боодол	Жилд 1 удаа	-	-	
	Аюултай хог хаягдлын зэрэглэлээс хамааран хог хаягдлын цэгт хамгаалалтын бүс хашаа татах. Хамгаалалтын бүсийн бүрэн бүтэн байдлыг хангах, хог хаягдлуудыг эмх цэгцтэйгээр байршуулах, тэмдэг тэмдэглэгээ байршуулах	Аюултай хог хаягдал түр хадгалах байршилд	I улиралд	-	-	
Хог хаягдлын бүртэгэл мэдээлэл хөтлөх	Хог хаягдлын нэгдсэн бүртгэлийг хөтлөх. Хог хаягдлын бүртгэл, баталгаажуулалтыг үргэлжлүүлэн гүйцэтгэх. Хог хаягдалтай холбоотой бүх төрлийн мэдээллийг баримтжуулж, мэдээллийн сан үүсгэж байх. Баримтжуулалтын хүрээнд дараах үндсэн мэдээллийг хөтлөх • Хог хаягдлын төрөл • Хог хаягдлын хэмжээ • Огноо • Хог хаягдлын хэрхэн ангилсан • Хог хаягдлыг хэрхэн зайлуулсан тухай	Төслийн хэрэгжих талбайд	Өдөр бүр	Байгалт орчны мэргэжилтэн		
НИЙТ				-	**2.0**	

4.4 Тохижилт ногоон байгууламжийн төлөвлөгөө

Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн зорилт	Нөхөн сэргээлтийн арга	Арга хэмжээний цар хүрээ	Хэрэгжүүлэх хугацаа давтамж	Нэгжийн зардал сая.төг	Нийт зардал сая.төг	Баримтлах стандарт, аргачлал
Хөрсний үржил шимт байдлыг хадгалах, агаарт тоосжилт үүсэхээс урьдчилан сэргийлэх, орчны өнгө үзэмжийг сайжруулах	Үржил шимт х өрсөөр хучих, хөрсийг сайжруулах	1.5 га талбайд	II улиралд	1.0	5.0	Байгаль орчныг хамгаалах тухай хууль Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль MNS 5914:2008 Эвдэрсэн газрын нөхөн сэргээлт стандартын дагуу нөхөн сэргээх.
Талбай (15 га)-н 10 хувиас багагүй талбай (1.5га)-д ногоон байгууламж байгуулах	Сөөг сөөгөнцөр тарих	1.5 га талбайд	Хаврын болон намрын тарилт хийх	-	-	
НИЙТ					**5.0**	

4.5 Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

Гол ба болзошгүй сөрөг нөлөөлөл	**Урьдчилан сэргийлэх бууруулах арга хэмжээ**	**Арга хэмжээний цар хүрээ**	**Хэрэгжүүлэх хугацаа давтамж**	**Нэгжийн зардал**	**Нийт зардал сая.төг**	**Баримтлах стандарт, аргачлал**
Байгалийн гамшиг, аюулт үзэгдлээс үүдэн болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах						
Үйлдвэр усанд автах, техник хэрэгсэлд саатал үүсч орчин бохирдох	“Гамшгийн эрсдэлийн нарийвчилсан үнэлгээ” мэргэжлийн байгууллагаар боловсруулах	Эхний жилд	I улиралд	1.4	1.4	Гамшгаас хамгаалах хууль
Химийн бодисын эрсдэлийн үнэлгээний дүнд тогтоосон аюултай болон хортой химийн бодис алдагдахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ						
Нүүрсээр ажиллах халаалтын	Нүүрсний шаталтаас бий болох тоос, хүхрийн оксидууд (SOx), азотын оксидууд (NOx), Зарим шатдаггүй хэсгүүд буюу	Үйлдвэрийн ажиллах хугацаанд	Тогтмол	-	-	Бнба дүрэм

зуухан дах нүүрсний шаталт, түлшний бүтэц, уурын зуухны хэлбэр хэмжээ, шатаах нөхцөл, ачааллаас шалтгаалан үүсэх бохирдолт ЗДА-аас хэтрэх эрсдэл үүсэх	нүүрстөрөгчийн оксид (CO), бусад органик нэгдлүүд нь уурын зуухны үйл ажиллагааны нөхцөлөөс хамаарах тул аль ашиглаж буй уурын зуухын ажиллагаанд хяналт тавих					
	Үйлдвэрт ашиглагдах химийн бодисыг стандартын шаардлага хангасан агуулахад хадгалах	Төслийн талбайд	байнга	-	-	MNS 4628:2013
Химийн бодис, шатах тослох материалын хадгалалт, ашиглалтаас хүний эрүүл мэнд ба хүрээлэн буй орчинд сөрөг нөлөөлөл үзүүлэх	Шатах тослох материал ачиж буулгах, цэнэглэх хэсгийг хатуу хучилттай болгон, алдагдаж асгарсан тохиолдолд хөрсөнд нэвчүүлэхгүй байх арга хэмжээг авч хэрэгжүүлэх	ШТС	-	1.5	1.5	Химийн хортой ба аюултай бодисын тухай хууль , MNS 4628:2013. “Шатахуун түгээх станц. Галын аюулгүйн норм”
	Үйл ажиллагаанд ашиглагддаг химийн бодис, шатах тослох материалын бүртгэл тооллого хийх, тайлагнах	Төсөлд ашиглах химийн бодис түүний хэрэглээ	IV улиралд	-	-	
	Химийн бодисын асгаралтын багцыг ХБ асгарах магадлалтай газар байршуулах	Хяналтын лаб Баяжуулах үйлдвэр	I Улиралд	1.0	1.0	
Гал түймрээс урьдчилан сэргийлэх бууруулах арга хэмжээ						
Химийн бодисын агуулах, автомашин, ажилчдын байр, цахилгаан үүсгүүр бүхий газруудад гал түймэр гарах	Бүх ажилчдыг гал түймэр унтраах сургалтад хамруулах	Нийт ажилчид	Жилд 1 удаа	-	-	Галын аюулгүй байдлын тухай хууль, 16-р зүйл, MNS5566:2008 MNS0640:89 MNS639:89 MNS 4628:2013.
	Галын дохиолол, гал унтраах багаж хэрэгслийг шаардлагатай газруудад байрлуулах Гал түймрээс сэргийлэх талаар анхааруулга, санамжийн хуудас хийж, шаардлагатай газруудад нүдэнд харагдахуйц газруудад байрлуулах	Үйлдвэрийн хотхон, Засварын газар Химийн бодисын агуулах ШТС-ийн талбайд	I улиралд	-	0.5	

магадлалтай. Мөн хаврын хуурайшилт ихтэй өдрүүдэд тамхины цог зэргээс хээрийн түймэр гарч болзошгүй	хуурайшилт ихтэй саруудад гал унтраах хэрэгслийн бүрэн бүтэн байдалд хяналтыг ойртуулах тавих					“Шатахуун түгээх станц. Галын аюулгүйн норм”
Үйлдвэрлэлийн ослоос урьдчилан сэргийлэх арга хэмжээ						
Ажилчид бэртэх, эрүүл мэнд хохирох, амь нас эрсдэх, үйлдвэрийн үйл ажиллагаа саатах, тоног төхөөрөмж эвдэрч гэмтэх	Осол аваар гарч хүний эрүүл мэнд хохирсон тохиолдолд яаралтай анхан шатны тусламж үзүүлэх, анхан шатны тусламжийн эмийн санг ажлын байранд байрлуулах	Ажилчдын кемп болон үйлдвэр			0.5	Эрүүл ахуйн тухай хууль, MNS 4990:2023
Нийт зардал 4 900 мян.төг						

4.6 Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний зорилт	Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээ	Хэрэгжүүлэх хугацаа давтамж	Нэгжийн зардал мян.төг	Нийт зардал сая.төг	Баримтлах стандарт аргачлал
Доройтсон амьдрах орчныг сайжруулах	Сумын хог хаягдлын цэгийг түрж, хумих. Хог хаягдлын талбайг хянах, тэгшлэх, засах	Сар бүр	1250.0	15.0	БОАЖ-ын сайдын 2018 оны А/445 дугаар тушаал, “Энгийн хог хаягдлын төвлөрсөн цэгийн болон хог хаягдлыг сэргээн ашиглах, устгах, булшлах үйл ажиллагаа эрхлэх” журам

4.7 Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

Хяналт шинжилгээ хийх үзүүлэлт	Байршил	Хэрэгжүүлэх хугацаа давтамж	Нэгжийн зардал (мян.төг)	Нийт зардал мян.төг	Баримтлах стандарт, аргачлал
Агаарын чанар					
Зөөврийн багажаар: Агаар бохирдуулагч хийнүүд: SO2, NO2 Тоосонцор: PM10, PM2.5	Үйлдвэрийн талбайд, Хаягдлын сангийн дэргэд Кемп	Жилд 2 удаа 6 болон 9 сард	133	267.0	MNS 4585:2016 MNS:3384:1982 MNS:4048:1988 MNS 4585:20216 MNS:3384:1982 MNS 4048:1988
Гадаргын болон газар доорх ус					
Гадаргын болон газрын доорх усны чанар: Гол ионы найрлага: анион, катион, микро элементийн агууламж	Ус хангамжийн цэг	Жилд 4 удаа буюу улирал тутам	60.0	242.0	MNS (ISO) 5667-1:2002 MNS (ISO) 5667-1:2004 MNS ISO 5667-5:2001 MNS 900-2018 MNS 6148;2010 MNS 4586 : 1998
Газрын доорх усны түвшин, хэмжих	Мониторингийн цэгт	Жилд 2 удаа	-	-	-
Микро элемент	Эргэлтийн усан сан	Жилд 2 удаа	120.0	240	MNS (ISO) 5667-10:2001 “Усны чанар.дээж авах. 10-р бүлэг. Хаягдал уснаас дээж авах заавар”
Ахуйн бохир усны цооногийн бохир ус: pH, Ж/б, ХХХ, БХХ, NH4, NO2, NO3, N-нийт, P-эрд	Ахуйн бохир усны цооногт	Жилд 2 удаа	90.0	180	
Хөрсөн бүрхэвч					
Хөрсний ерөнхий химийн үзүүлэлтүүдийг хянах	Үйлдвэрийн бүс Кемп Харьцуулах хөрс	Жилд 2 удаа	65.8	394.8	MNS 5850 : 2019 MNS 3298 : 1991
Хөрсний өнгөн хэсэг дэх хүнд металын агууламж	Кемп Хог хаягдалын цэг Засварын төв	Жилд 2 удаа 7 цэгт	30.8	431.2	MNS 5850 : 2008 Хөрсний чанар. Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ

(Pb, Cd, Hg, As, Cr, Sn, Sr, V, Cu, Ni, Co, Zn, Mo, Se, B, F, CN-)	Агуулах Хүдрийн овоолго Баяжуулах үйлдвэр Хаягдлын сан				
Нян бактерийн шинжилгээ	Хог хаягдлын цэгт	Жилд 1 удаа	50.0	50.0	
Амьтны аймаг					
Эргэлийн усан болон хаягдлын санд ирж буй шувууд, тэдгээрийн төрөл, тоо, давтамжийн хаянах, бүртгэл хөтлөх	Эргэлтийн усан сан	Дулааны улиралд жилд 1 удаа	-	-	Амьтны тухай хууль, Ажиглах болон дээж талбайн тооллого Цэгэн ажиглалт, трансектийн аргууд
Дуу чимээ					
Дуу чимээний түвшинг хэмжих	Үйлдвэрийн бүс Кемп	2 цэгт жилд 1 удаа	50.0	100.0	MNS 4585:2016
НИЙТ				**1905.0 мян.төг**	

4.8 Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага, зохион байгуулалтын төлөвлөгөө

№	Арга хэмжээ	Хэрэгжүүлэх хугацаа давтамж	Нийт зардал сая.төг	Хариуцах албан тушаалтан
1	Ажилтнуудад байгаль орчны сургалтуудыг ажлын байранд нь зохион байгуулах	Жилд 1 удаа (I улиралд)	1.0	Байгаль орчны мэргэжилтэн
2	Жил бүр нийт ажилчдыг гэнтийн ослын даатгалд хамржуулах	Төлөвлөгөөт онд	2.0	Үйлдвэрийн менежер
3	Жил бүрийн байгаль орчны менежментийн төлөвлөгөө ба тайлан боловсруулах	Төлөвлөгөөт онд	-	Байгаль орчны мэргэжилтэн
Нийт зардал			3.0	

4.9 БОМТ, түүний хэрэгжилтийг оролцогч, сонирхогч талуудад тайлагнах, хэлэлцүүлэх хуваарь

№	**БОМТ-ний биелэлтийг тайлагнахад оролцогч талууд**	**Тайлагнах хэлбэр**	**Мэдээний агуулан**	**Зохион байгуулах хугацаа тов**	**Нийт зардал мян.төг**	**Зохион байгуулах газар**
1	Баянжаргалан сумын багийн иргэд	ИНХ-д танилцуулах	Тухайн жилд хийгдсэн ажил	Тухайн оны 4-р уилралд	500.0	Багийт төв
2	Дундговь аймгийн Байгаль орчны газарт	https://eic.mn/envmng/ буюу Байгал орчны мэдээллийн санд оруулах	Тухайн жилд байгаль орчны талаар хийгдсэн ажил нөхөн сэргээсэн ажлын акт болон холбогдох материал	Тухайн оны 11 –р сарын 1 дотор	-	Дундговь аймгийн төв
3	Төрийн захиргааны төв байгууллага	https://eic.mn/envmng/ буюу Байгал орчны мэдээллийн санд оруулах, тамгалуулах		Тухайн оны 12 –р сарын 1 дотор	-	Төрийн захиргааны төв байгууллага

2026 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нийт зардал 37 915 000 төг зарцуулах бөгөөд эдгээр нь БОННҮ-ний тайланд тусгагдсан дүнгээр энэ онд хэрэгжүүлхээр төлөвлөсөн болно. Үүнд:

- Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний зардал – 5 610 мян.төг
- Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний зардал – 2 000.0 мян.төг
- Ногоон байгууламжийг нэмэгдүүлэх ажлын төлөвлөгөөний зардал – 5 000.0 мян.төг
- Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний зардал – 4 900.0 мян.төг
- Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний зардал - 15 000.0 мян.төг
- Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн зардал – 1905.0 мян.төг
- Удирдлага зохион байгуулалтийн төлөвлөгөөний зардал – 3 000.0 мян.төг
- БОМТ хэлэлцүүлэх, тайлагнах зардал – 500.0 мян.төг